



МОНГОЛ УЛСЫН  
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

\_\_\_ оны \_\_ сарын \_\_ өдөр

Дугаар \_\_\_

Улаанбаатар хот

Татварын алдангийн  
хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Татварын ерөнхий хуулийн 73 дугаар зүйлийн 73.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Татвар төлөгчийн хуулиар тогтоосон хугацаанд төлөөгүй татварт тооцох алдангийн хэмжээг хоног тутамд 0.06 хувь байхаар тогтоож, 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Татварын албанаас үндэслэлгүй, илүү хураасан татварт тооцох алдангийн хэмжээг хоног тутамд 0.05 хувь байхаар тогтоож, 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Татварын алдангийн хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2019 оны дүгээр сарын .... -ний өдрийн .... дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Ч.ХҮРЭЛБААТАР

## ТАНИЛЦУУЛГА

## ТАТВАРЫН АЛДАНГИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Татварын ерөнхий хуулийн 73 дугаар зүйлийн 73.1-д “Татвар төлөгчийн хуулиар тогтоосон хугацаанд төлөөгүй татварт, эсхүл татварын албаны үндэслэлгүй илүү хураасан татварт тус тус алданги тооцох бөгөөд тухайн татварын жилд мөрдөх алдангийн хэмжээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тухайн татварын жилийн 1 дүгээр сард багтаан дараахь зарчмыг үндэслэн тогтооно, мөн зүйлийн 73.1.1-д “татвар төлөгчийн хугацаандаа төлөөгүй татварт тооцох алдангийн хэмжээг Монголбанкнаас зарласан арилжааны банкуудын зээлийн хүүгийн жилийн жигнэсэн дунджаас 20 хувиар илүү байхаар; 73.1.2-д “татварын албанаас үндэслэлгүй илүү хураасан татварт тооцох алдангийн хэмжээг Монголбанкнаас зарласан арилжааны банкуудын зээлийн хүүгийн жилийн жигнэсэн дундаж байхаар” гэж заасны дагуу татварын алдангийн хэмжээг тогтоож байгаа болно.

Төсөлд татвар төлөгчийн хуулиар тогтоосон хугацаанд төлөөгүй татварт тооцох алдангийн хэмжээг хоног тутамд 0.06 хувь байхаар, Татварын албанаас үндэслэлгүй, илүү хураасан татварт тооцох алдангийн хэмжээг хоног тутамд 0.05 хувь байхаар тогтоож тусгалаа. Алдангийн хэмжээг тогтоохдоо арилжааны банкнаас олгож буй төгрөгийн зээлийн хүүгийн жигнэсэн дунджид үндэслэсэн бөгөөд 2018 оны эхний 8 сарын байдлаар төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү жилийн 18.59 хувь, сарын 1.55 хувь, хоногийн 0.051 хувь байна.

Арилжааны банкнуудын төгрөгийн зээлийн дундаж хүү, сараар

Он	Сар	Төгрөгийн зээлийн дундаж хүү		
		жил	сар	хоног
2018	1	19.20	1.60	0.053
2018	2	18.90	1.58	0.052
2018	3	18.90	1.58	0.052
2018	4	19.10	1.59	0.052
2018	5	18.50	1.54	0.051
2018	6	17.70	1.48	0.048
2018	7	18.30	1.53	0.050
2018	8	18.10	1.51	0.050
<b>2018 Дундаж</b>		<b>18.59</b>	<b>1.55</b>	<b>0.051</b>
<b>+20 хувь</b>				<b>0.061</b>

Эх сурвалж: [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)